

ДеФакто **ТОЙМ**

➤ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭРГЭН ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛ 1.3 ИХ НАЯД ТӨГРӨГТЭЙ ТЭНЦЭЖ БАЙНА

➤ СТАНДАРТ БАНКИНД ТӨЛСӨН 40 САЯ ДОЛЛАРЫГ ХЭН БУЦААЖ ТӨЛӨХ ВЭ?

➤ ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛЫН ҮЕЭР МОНГОЛЫН ТАЛЫН САНААЧЛАГА МУУ БАЙСАН УУ?

VIII НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ХЯМД ТУСМАА
ҮНЭТЭЙ

II НҮҮРТ

САМУРАЙ

IV НҮҮРТ

Бушидо

V НҮҮРТ



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

EQ БА
МЭДРЭМЖ

VI НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.09.11, №10 (114)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com





Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

ХЯМД ТУСМАА ҮНЭТЭЙ

Монгол улсын замын хөдөлгөөнийг баруун гарын дүрмээр зохицуулдаг хуультай (de jure). Энэ нь замтай ч бай, үгүй ч бай хоёр машин зөрвөл баруун гар талаа барьж явна гэсэн үг. Манай улсын замын хөдөлгөөнтэй холбоотой бүхий л дүрэм журам, дэд бүтэц нь тээврийн хэрэгслүүдийг зүүн талдаа жолооны хүрдтэй байхаар тооцож хийгдсэн юм.

Гэтэл 2015 оны эцэс гэхэд Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй 440 мянган автомашины 54 хувь нь (de facto) баруун талын хүрдтэй байсан аж. Тус онд Монгол улсад нийт 37 мянган автомашин оруулж ирсний 34 мянга нь Японд үйлдвэрлэсэн байх юм. Үнийн дүнгээр нь үзвэл, 210 сая доллар болсны 180 сая нь буюу 86 хувь нь Японы машинд ногдож байна.

Япон, Монгол хоёр улсын хооронд байгуулсан чөлөөт худалдааны гэрээгээр (ЕРА) шинэ машинаас

ЗАМ САЙЖРАХ ТУСАМ ОСОЛ ИХСЭВ

Аливаа улсын замын хөдөлгөөн нь тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршилтай зохицож байж л аюулгүй, шуурхай болж, түгжрэл үүсэх нь багасна.

Нийслэлд 2014 онд зам, тээврийн 11,630 осол гарсны 59 хувь нь баруун талдаа жолооны хүрдтэй (дүрэмтэйгээ харшилсан буюу буруу талдаа жолооны хүрдтэй) машин байсан бол 2015 онд Монгол улсад гарсан нийт 41,064 авто ослын 64.4 хувь нь буруу талдаа жолооны хүрдтэй байсныг Замын цагдаагийн газрын мэдээнээс харж болно. Ганцхан жилийн дотор зам, тээврийн осол бараг дөрөв дахин өсчээ.

Буруу талдаа жолооны хүрдтэй машин барьж яваа жолооч өмнөх машинаа гүйцэж түрүүлэхийн тулд машинаа бүтэн биеэр тэр машины зүүн

гадна 36 сар хүртэлх насжилттай машин татваргүй, түүнээс дээш настай бол таван хувийн хөнгөлөлттэй татвар авах болсон нь баруун талдаа жолооны хүрдтэй, японы машинууд цаашид ч нэмэгдэхийг харуулж буй. Тэнд 10-аас илүү настай машинунахыг хориглосон хуультай тул долоогоос найман настай машиныг гадаадад хямдхан гаргах сонирхол их байдаг. Монгол улсын Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2011-2015 онд Монголоос Япон руу нийтдээ 72 сая долларын экспорт хийсэн бол Японоос Монгол руу хоёр тэрбум долларын экспорт хийжээ. Түүний 1.3 тэрбум доллар нь автомашин бол нийт автомашины 66 хувь нь "Prius" гэнэ.

талд гарч, замаа харахаас өөр аргагүй учраас нийт хөдөлгөөн болон тухайн машины хурдаас хамаараад осол зөрчил ихээхэн тохиолддог. Ялангуяа Улаанбаатар хотын зам сайжрах тусам хөдөлгөөний хурд нэмэгдэж, ослын тоо огцом өсөх болсныг бүтээн байгуулалтын он жилүүд харуулж байна.

Монгол улс 2012-2015 онд 6351 км хатуу хучилттай зам тавьсан бол 2016-2021 онд 5700 км хатуу хучилттай зам тавихаар төлөвлөжээ. Хөдөөгийн ихэнх зам хоёр урсгалтай, дунд нь тусгаарласан зураас байхгүй учир жолооч нар нүдэн баримжаагаар, өндөр хурдтайгаар зөрдөг. Замын олон нүх, саадыг тойрох гэж жолооч нар машинааа ▶▶

- ▶ хүрдийг огцом мушгиснаар осол гаргаж байна.

Хот суурин газруудад нэвтрэх, машинаа зогсоолд байрлуулах, онгоцны буудал орох, гарах зэрэг олон газарт буруу талдаа хүрдтэй машины жолооч тасалбар авах, мөнгө төлөх гэж нөгөө талынхаа цонхоор гараа цухуйтлаа сунах гэсээр хөдөлгөөний хурдыг сааруулдаг. Зүтгээд зүтгээд амжилтгүй болсон нь машинаасаа бүр гарч тойрох нь бий. Мөн ихэнх нь баруун талдаа жолооны хүрдтэй учир Монголд хамгийн зүүн талын шугам нь хамгийн хурдан байх дүрэм аль хэдийн үйлчлэхээ больсноос замын шугамын хурдны ялгаа арилсан.

ШИЙДЭХ АРГА БЭЛЭН БАЙНА

Замын хөдөлгөөний баруун, зүүн дүрмийн ялгаа үүссэн нь Дундад зуунаас эхлэлтэй. Хот суурин бүрдэхийн хэрээр нэг замаар олон хүн явах болж, ихэнх хүн солгой биш тул морьтой хүн зүүн талдаа сэлэмтэй, баруун гараараа сэлмээ хэзээ ч сугалахад бэлэн явдаг байснаас зүүн гарын хөдөлгөөн бүх оронд хэвшжээ. 1700-аад оноос Америк болон Францад фермийн аж ахуй эрчимтэй хөгжиж, цуваа морин тэргээр хот руу хүнс тариа зөөдөг болсон байна. Харин хүн нь хамгийн сүүлчийн, зүүн талын морин дээр мордож зүүн гар талаа тод харах, бас баруун тал руу морьдоо шилбүүрдэх болсноор баруун гарын замын хөдөлгөөн үүсчээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үүднээс аль ч улс орон нэг бол баруун, эсвэл зүүн гарын дүрмийг л сонгож ирснийг түүх гэрчилнэ. Үүнийг дагаад буруу талдаа хүрдтэй машинуудыг импортлох, замын хөдөлгөөнд оруулахыг хориглодог болсон байна. Камбожийн автомашиных нь бараг 80 хувь нь Тайландаас импортлох, буруу талдаа хүрдтэй

Нэг ч бай, гурав ч бай бүгд л яг адилхан хурдтай шугамуудтай боллоо. Байраа зөв эзлэхийг шаардвал бараг зодуулчих шахна.

Шөнийн цагт хөдөөгийн зам дээр монголын олон жолооч холын гэрлээ шилжүүлдэггүй учир хурц гэрлийн гялбаанд замаа харахгүй, мэдрэмжээрээ баримжаалахад хүрдэг. Буруу хүрдтэй машины холын гэрлийн тусгал замаасаа гадагшаа чиглэл бүхий тохируулгатай болохоор баруун гарын дүрэмтэй оронд тэр гэрэл нь зам руугаа чиглэн нүд улам хүчтэй гялбуулдаг. Тийм учраас хоёр эсрэг дүрэмтэй Англи, Францын хил дээр машинуудын том гэрлийг нь бууруулах хальс төлбөртэй наадаг юм. Наагаагүй жолоочийг очсон хот бүхэнд нь цагдаа торгоно.

байсныг шинэ зуун гарснаас хойш хориглож, хүрдийг нь зөв тал руу нь тавиулж эхэлжээ. Манай хойд хөрш Орос ч мөн Японы автомашинуудын жолооны хүрдийг зүүн гар талынх болгон өөрчилдөг болов.

Ерөнхий сайд Сү.Батболдын Засгийн газрын үед буюу 2012 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги баталжээ. Энэ стратегид зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн эзлэх хэмжээг 2012 оны суурь түвшин 54 хувиас 2015 он гэхэд 75, 2020 он гэхэд 95 хувьд хүргэнэ гэж заасан байх юм. Харамсалтай нь монголын хууль гурав хоног гэдэг шиг үүнд хэн ч хяналт тавихаа больж, буруу хүрдтэй машин нь дээрх хувийг эзлэх хандлагатай байна. Уг нь Зам, тээврийн яам үүнийг хариуцах ёстой ч монголын яамдын нэр, бүтэц нь үргэлж өөрчлөгддөг тул олон ажил буух хаяг, буцах эзэнгүй орхигдож, хэн ч хариуцахгүй үлддэг болоод удлаа.

Үүний эсрэг хамгийн оновчтой арга нь юу байж болох вэ. 2020 он гэхэд бүх машин зүүн талдаа жолооны хүрдтэй байна, түүнээс цааш буруу хүрдтэй машиныг хилээр оруулахгүй гээд л хууль гаргаад нийтэд зарлачихвал хэчнээн олон хүний амь насыг авто ослоос аварч, замын хөдөлгөөний түгжрэлийг багасгах бол. Харин буруу хүрдтэй машин давамгайлж буйгаас Монгол улс зүүн гарын дүрмийг авчих юм бол хоёр хөршөөсөө эсрэг замын хөдөлгөөнтэй болж, юун коридор болох, харин хоолойд тээглэсэн бүлх лүгээ хил дээр гацах болно гэдгээ төрийн түшмэд тунгааж байгаа болов уу даа.

Тийм хууль гаргаад л дөрвөн жилийн өмнө зарлачихад хэнд юу саад болоод байгаа юм бол оо, төр засгийнхаан. Зам, тээврийн осолд хэчнээн иргэнээ алдсаны дараа үүнийг хийх гэсэн юм бэ.

2016.09.28

САМУРАЙ

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсад айлчлав. Япон, Монголын харилцаа төр засгийн түвшинд улам бүр бэхжин өргөжиж, Япон улс Монголын хөгжилд ихээхэн тусламж олон жил үзүүлж ирсэн юм. Тэд биднийг гал алдах шахаж байхад цахилгаан станцыг нь засч, нүүрсээ олборлох хөрөнгө хүчгүй болж байхад эргэлтийн хөрөнгө өгч, нийслэл хотын нийтийн тээвэр зогсох гэж байсан өвөл 50 автобус явуулж, улс орон даяар ерөнхий боловсролын олон арван шинэ сургууль барьж өглөө. Удалгүй урт хугацааны зээлээр онгоцны буудал барих гэж байна.

Энэ бүхэнтэй цуг хэрэглээний шинэ соёл ирж байна. Харин Японы бизнес Монгол руу яарахгүй байна. Гол шалтгаан нь Монголчуудыг урьдчилан таамаглаж болохгүйд буюу Монголчууд бидэнд итгэхэд хэцүү хэвээрээ байгаад оршиж байна. Уулзсан бизнесийн төлөөлөгчид “улс орны” болон бизнесийн “итгэлийн” эрсдэл өндөр байгаа тухай ярьж байна. Яг ийм яриа 10 жилийн өмнө болж байсан юм. Япон ба Монгол хүний хооронд нийгмийн харилцааны хувьд ойлголцлын асар их зөрүү байна.

Япон хүний үзэл бодлын суурь нь самурайн ёс зүй. Өөрийн үйл хэргийг төгс эзэмших, эрэлхэг зориг, тэвчээр хатуужилтай байх, даруу байх, амласан бол заавал гүйцэтгэх буюу хэлсэн үг бүрийнхээ төлөө бүрэн хариуцлага хүлээх гэх зэрэг гайхамшигт чанаруудыг тэд эрхэмлэн дээдлэж, үр удмаа хүмүүжүүлж байна. Япон хүний бүтээсэн бараа бүтээгдэхүүний чанар энэ бүхнийг гэрчилж байна. Японы 130 сая хүн мэдээж бүгдээрээ биш ч гэсэн, давамгайлж байгаа соёл нь одоо ч гэсэн самурайн ёс.

Японд очих бүртээ энэ ёсыг нь ухан ойлгож, тэднээс ч дутахгүйгээр, Монголчууд бидэнд байсан ёс зүйгээ хайж олох, сэргээх хүсэл үргэлж төрөх юм. Япончууд хүртэл өөрсдийгөө Монголчуудтай холбоотой, Монголын эрэлхэг зоригт баатрууд японы самурай нарын хооронд адил, төсөөтэй зүйл их гэж ярьж байна.


1192 онд Ёоритомо Минамото шёгун самурайн удирдагч Киото хотоос явж Камакура гэдэг газар суурьшин цэргийн хүчээ зузаатгаж, удалгүй бусад хот, газруудыг нэгтгэснээр Япон улсыг 700 жилийн турш захирсан самурайн дэглэмийн үндсийг тогтоожээ. Тэр хэмжээ хязгааргүй тансаглаж асар их эд бараа хэрэглэж 12 давхар кимонотой байсан хаад ноёдын хэт хэрэглээ, ард иргэд нь татварт шулуулан ядуурч байгааг эсэргүүцэн, зөвхөн амьд байхад шаардлагатай хүнс, барааг л

хэрэглэж хувьдаа эд хөрөнгө хураахгүй байж, биеийн хүчний хөгжлийг эрхэмлэсэн цэргийн самурайн ёс зүйг эрхэмлэсэн хатуу дэглэмийг тогтоосон юм. Түүний төрсөн дүү Ёсицуне Миномото, ахаасаа дутахгүй алдар нэртэй эрэмгий зоригтой, ухаалаг самурай байсан бөгөөд ах дүү хоёр төр засаглалын арга барилын хувьд зөрчилдөж байжээ. Дүү нь алга болсон бөгөөд Монголчуудтай нэгдсэн байж магадгүй гэх таамаглал хүртэл байдаг гэнэ. Хубилай хаан Япон руу 1274 болон 1281 онд хоёр ч удаа довтолсон боловч хүчтэй далайн шуурганд цохигдон олон зуун усан онгоц, цэргүүдээ алджээ. Энэ далайн шуургыг япончууд Камиказэ бурхны салхи гэж нэрлэсэн бөгөөд хожим нь японы төлөө амиа золиослогчдыг энэ нэрээр алдаршуулдаг болжээ.

Японы самурайн ёс заншил нь тэдний өнөөгийн амьдралд үзэл бодлын баримжаа чиглэл болж, тэднийг хариуцлагатай, сахилгатай, өрсөлдөх чадвартай болгож байна. Монголчууд бидний хатан зориг, тэвчээр хатуужил, ухаалаг чанарын түүхэн суурь нь хаана байна вэ?

Энэ хариултыг бид олж чадвал дээр хэлсэн нийгмийн харилцааны тухай Япон, Монгол хүмүүсийн ойлголтын зөрүүг ойртуулахад томоохон алхам болох байх. Энэ зөрүүг арай бага болж байж л бизнесийн хамтын ажиллагаа жинхэнэ утгаараа хөгжих болов уу.

2010.11.30



Бүшидо

Японд очих бүр энэ ард түмний хөдөлмөрч чанарыг харж бахдах юм. Япончуудын дотоод хөдөлгөгч хүчийг ойлгох хүсэл өөрийн эрхгүй гадаадын хүн бүрт төрдөг. Эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн он жилүүдэд ч, өсөлт нь буурсан сүүлийн арваад жилд ч, энэ орон улам бүр өнгө орж, амьдралын орчноо төгс болгосоор байна. Социализмын үеийн хэллэгээр "Капитализм ялзарч байна, гэхдээ үнэр нь их сайхан юм".

Гайхамшигтай ухаалгаар зохион бүтээсэн биет зүйлс нь, түүний дотор дэд бүтэц, агаарын, усан болон газрын замын сүлжээ, усан хангамж болон эргэлтийн систем, дэлхийн хамгийн том хот гэхэд Токиогийн цэвэрхэн агаар, хотын цэцэрлэг, микро орчныг бүрдүүлсэн, барьсан байшин, хийсэн бүтээсэн бүх зүйлийг нарийвчлан харахад үнэхээр ганц ч алдаа олдохгүй, жинхэнээсээ "Япончилчихсон" байх юм.

Аль ч орны ололт амжилтын суурь, иргэдийнх нь эдэлж хэрэглэж байгаа бодит болон оюуны бүтээгдэхүүний чанар, нийгмийн амьдралын нөхцөл нь хувь хүний оюун санаагаар (spirit) тодорхойлогддог гэдгийг Япон орон хамгийн тод илэрхийлдэг.

Нийгмийн аль ч давхаргад харьяатай бай, Япон хүн нэгэнт барьж авсан бол ямар ч ажлыг төгс хийх ёстой гэж үздэг юм байна. Ямар ч газраар орсон хийж байгаа ажилдаа төвлөрөөгүй, өөрийгөө хийж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээсээ илүү илэрхийлэх хүн харагдахгүй юм.

Энэ үндэстний нийгмийн амьдралыг бүрдүүлж байгаа суурь оюун санааг "БҮШИДО" гэдэг. Энэ бол 1868 он хүртэл бараг 800 жилийн турш Япон орныг засаглаж байсан самурай ангийн ёс зүйн систем. Бүшидо оюун санаа нь самурайн ангитайгаа цуг алга болоогүйгээр үл барам цаг хугацааны явцад харин ч утга агуулгын хувьд баяжин, сайн ч, саар ч, аль ч цагт Япон үндэстний эрч хүчний нөөц нь болж, Япон хүн байсан цагт хэзээ ч алга болохгүй гүнзгийгээр яс маханд нь шингэжээ.

Энэхүү оюун санаа нь Япон хүний гүн ухаан, сэтгэлийн итгэл үнэмшлийн суурь болж, улмаар хүмүүс хоорондын харилцааны ёс жаяг, гэр бүлийн амьдрал, хувцаслалт, ажиллах хэв хэмжээ, зөвхөн наад захын шаардлагатай зүйлээр өөрийгөө болгох ээстэтик мэдрэмж, бүр амарч баясах хүртэлх амьдралын бүх талыг нь чиглүүлэн залдаг юм байна.

Биет болон оюун санааны ертөнц харилцан бие биенээ бүрдүүлдэг, тэдгээрийг салгах, харилцааны тэнцвэрийг алдуулахад нийцэхээ болихыг Япончууд эрт дээр үеэс ойлгожээ. Тэд амьдрахын тулд дадлага туршлагатай болохын адилаар оюун санаагаа хөгжүүлэх шаардлагыг зэрэг тавьдаг. Бүши дайчин до зам гэдэг нь дайчин эрийн оюун санаа ба түүний чадвар, дадал гэсэн утгатай.

Өнөөдөр бизнесийн дээд амжилтад хүрсэн Япон хүн бүрийн гол зарчим бол бүшидо гэж тэнд олон жил амьдарсан гадаадын хүн надад хэлсэн юм. Японы менежментийн удирдлагын зарчим нь дарга хүн бүр үйл ажиллагааны алхам бүртээ өөрөө биечлэн хариуцлага хүлээдэг, хүмүүстээ ойлгомжтой, үнэн сэтгэлээсээ, ялгаварлалгүй, шударга харилцдаг, нэр төрөө хүндэлдэг, хэмжээ хязгааргүй эрч хүчээ дайчлан ажилладаг.

Япон хүн самурайн засаглалын үед эзэн ноёныхоо төлөө үйлчилж байсан бол одоо хэрэглэгч, үйлчлүүлэгчийн төлөө үйлчилж байгаагаар л эрин үеийн бүшидо ялгаатай. Саяхан "Тоёото" компанийн захирал А.Тоёода машины үйлдвэрлэлд нь алдаа гарсан тухайгаа Америкийн конгресст очиж тайлбар тавихад бүшидо хандлага нь харагдаж байсан.

Японд өргөнөөр хүлээн зөвшөөрч, бүгд даган мөрдөж байгаа ёс зүй бол хүн маш даруухан байх, хүний анхаарлыг өөртөө татахгүй байх, өөрийн авьяас чадварын тухай ярихгүй байх, өөрийн хүрсэн ололт амжилтаа хөөргөхгүй, бусдын амжилтыг хүндлэх зэрэг самурайн журмаас үүдэлтэй. Нэгэн алдартай пивоны сурталчилгаа: "Жинхэнэ эр хүн чимээгүй л байдаг юм. Саппоро" гэсэн байсан.

Энэ үзэл бодлыг нь ойлгон мэдэрч, хүндэтгэн хандаж чадвал Монголчууд бид Япон оронтой бүрэн хэмжээгээр хамтран ажиллах болно.

Мөн самурайгаас дутахгүй эр зоригтой, алдар гавьяатай Монголчууд бидний оюун санааг илэрхийлсэн, амьдралынхаа алхам бүрт баримтлах ёстой Монгол "Бүшидо"-гоо энгийн ойлгомжтойгоор бичгээр буулгаж, дотроо шингээж чадвал бидний ололт амжилтад ихээхэн нэмэр болох байх даа.

2010.03.10
Токио-Улаанбаатар



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР
Ph.D /Боловсрол судлал/



EQ БА МЭДРЭМЖ

Японы эртний үлгэрт өгүүлснээр, нэгэн түрэмгий самурай там ба диваажинг тайлбарлаж өгөөч гэж Зэн багшийг сорьжээ. Зэн багш үл тоомсорлон “Чи бол зүгээр нэг бүдүүлэг этгээд, би чам шиг хүмүүст цагаа гарздаж чадахгүй” гэж хэлээд түүн рүү довтолтол самурайн уур хилэн бадарч, илдээ хуйнаас нь сугалаад “Энэ мунхаг явдлын чинь төлөө би таныг хөнөөж чадна шүү” гэж хашхиртал, Зэн багш “Энэ чинь л там юм шүү дээ” гэж тайвнаар хариулав. Өөрийг нь эзэмдсэн уур хилэнгийн талаар багшийн айлдсан зүйлээс үнэнийг олж ухаарсан, самурай тайвширч, илдээ хураагаад багшид талархан мэхийн ёслоход “Энэ чинь л диваажин юм шүү дээ” гэж хэлсэн гэдэг.

ӨӨРИЙГӨӨ ТАЙВШРУУЛАХ ЧАДВАР

Хүүхдээ “хүн шиг хүн” болгож төлөвшүүлэхийн гол цөм нь тусгай онол, гэр бүлийн нарийн дүрэм журам, эсвэл зан байдлын томьёонд оршдоггүй. Харин хүүхдийнхээ төлөө гэсэн гүн гүнзгий хайр халамж буюу хүүхдийнхээ баярлах, гуниглах, уурлах, ганцаардах, айх гэх мэт мэдрэмжийг хуваалцан, ойлгож хүн ёсоор харьцахад оршдог.

Эцэг эх, асран хамгаалагчид нь эрүүл, эерэг харилцан, ханддаг хүүхдүүд өөрөө өөртөө ч мөн адил эрүүл эерэг ханддаг, сэтгэл хөдлөлийн хувьд өөрийгөө тайвшруулах дадалтай байдаг тул сэтгэл хөдлөлийн тархи нь өөрчлөлт, эмзэглэл багатай байдаг байна.

Зарим эцэг эхчүүд хүүхдэдээ хүч хэрэглэдэг шалтгаанаа тайлбарлахдаа “алгадахад хүүхэд үгэнд нь ордог” гэсэн байна. Үнэн хэрэгтээ

хүүхэд бие махбодын зовиураас зугтааж эцэг эхийнхээ үгэнд орох нь элбэг байдаг. Алгадаж сүрдүүлэх нь богино хугацаанд үр дүнтэй байж, муухай аашлахыг даруй зогсоодог ч урт хугацаанд эсрэгээрээ муу үр дагавартай. Учир нь хүч хэрэглэх нь хүүхдэд хүч чадалгүй, шударга бус хандсан мэдрэмж төрүүлж, эцэг эхдээ уурлан, өөртөө дүгнэлт хийж сайжрахаас илүүтэй өс санах хандлага бий болдог. Дорд үзэгдсэн мэдрэмжээсээ болж хүүхдүүд буруу хийсэн үйлдэл гэмээ нууж, баригдахгүй байх арга сүвэгчилж эхэлдэг. Хүч хэрэглэх нь хүссэн зүйлээ авах арга зам гэсэн жишгийг хүүхдэд харуулдаг. Зодуулдаг хүүхэд ялангуяа өөрөөсөө жижиг, сул дорой хүүхдийг зодох, түрэмгийлэх хандлагатай болж, насанд хүрэх үедээ түрэмгий харилцаатай болдог нь судалгаагаар тогтоогдсон байдаг.

Хүүхэд баярласан, гунигласан, уурласан, айсан, гомдсон үед эцэг эх нь хамгийн их хэрэгтэй байдаг. Сэтгэл нь гонсойсон хүүхдээ тайтгарахад нь туслах чадвар бол эцэг эхийн хайрын онцгой илэрхийлэл. Хүүхдийнхээ сэтгэл хөдлөлийг бид ойлгож хуваалцсанаар, өөрийгөө тайвшруулах чадвар буюу насан туршидаа өөрийгөө удирдах ур чадварт суралцахад нь түүнд туслаж байгаа үйлдэл.

- ♦ Таны 5 настай хүүхэд шүдний эмч рүү явахыг хүсэхгүй, түгшүүртэй байгаа үед эмнэлгийн сандал дээр түүний айдас нь тэсэрч хашгирч, орилохоос өмнө мэдэрч, тайвшруулан, учир байдлыг ойлгуулах нь чухал.
- ♦ Таны 12 настай хүүхэд сагсан бөмбөгийн багт өөрийнх нь хүссэн байр сууринд сайн найз нь очсоноос болж атаархсан бол та тэднийг муудалцахаас нь өмнө тэр талаар хүүхэдтэйгээ ярилцах боломж гаргах учиртай. Ингэснээр таны хүүхэд асуудлыг томорч тэсрэхээс өмнө сэтгэл хөдлөл, мэдрэмжээ бага дээр нь хуваалцан

ярилцаж, асуудлыг шийдвэрлэх ур чадварт суралцана.

Нийгмийн сайн, муу олон талын нөлөөлөл дунд таны хүүхдийн сэтгэл, мэдрэмж ямар байгааг анзаарч байх нь эцэг эхийн үндсэн үүрэг. Энэ нь гэдэс цатгалан, мөр бүтэн юугаар ч дутаахгүй өсгөж байна гэдэг жишгээс өргөн утга агуулга юм. Өсвөр насныхан хүнд хэцүү үедээ хэнд ханддаг талаар асуухад ихэнх нь найз нөхөддөө гэж хариулсан байдаг. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сэтгэл хөдлөлийг ойлгож, мэдрэхийн тулд нүүрний хувирал, хөмсгөө зангидах, шүдээ зуух, хөлөө дэвслэх зэрэг түүний биеийн хэлэмжид анхаарлаа хандуулах нь маш чухал. Хүүхдээ сонсох үедээ тайван хандаж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд нь туслаж, хүүхдээ шүүмжлэхгүйгээр ярьж буй зүйлийг нь ойлгож, мэдэрдэг байх нь хайр, халамжийн илэрхийлэл. Хүүхэдтэйгээ нэг түвшинд нүүр тань байхаар суугаад, гүнзгий амьсгаа авч, тайван, анхаарлаа төвлөрүүлэн, чин сэтгэлээсээ санаа тавьж байгаагаа мэдрүүлэн түүнийг сонсох нь үр дүнтэй.

ХҮҮХДИЙН МЭДРЭМЖИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Эцэг эхчүүдийн ихэнх нь хүүхдээ алдаа гаргахад нь дооглож, хамгийн энгийн зүйлийг хийх гэж хичээх үед нь хүртэл ямар ч шалтгаангүй хүчлэх зэргээр тэднийг өөртөө итгэх итгэлээ алдах нөхцөл байдлыг бүрдүүлдэг. Мөн ямар ч бодлогогүйгээр хүүхдээ “сахилгагүй, дуу муутай, залхуу, онгиороо, толгой муут” гэх мэт нэр хоч өгч, доог тохуу хийх, шоолох шүүмжлэх, ёжлох, дорд үзэх зэргээр тоглоом наргиан хийхгүй байхад онцгой анхаарах нь чухал. Харин хүүхдэдээ шинэ зүйл суралцах боломж олгож, цөөн алдааг хүлээн зөвшөөрч, урам хайрлаж, магтах нь шийтгэхээс хэдэн арав дахин үр дүнтэй.

Хүүхдүүд эцэг эхийнхээ хэлсэн бүх зүйлд итгэх хандлагатай байдаг. Тиймээс тоглоом наргиагаар ч гэсэн хэт их шүүмжлэх, хүчлэх, дорд үзэх хандлага гаргаад байвал хүүхдүүд цаашид өөртөө болон ойр дотны хүмүүстээ итгэхээ больдог. Улмаар дотно харилцаа, итгэлцэл бага багаар алдагдаж, харилцаанд нь шүүмжлэл давамгайлж, хамтдаа асуудлаа шийдвэрлэн, ойлголцоход хана хэрэм үүсдэг.

Тиймээс хүүхдийнхээ баяр, гунигтай бүхий л мэдрэмжийг хуваалцан, зөв үг сонгон ярилцаж, айдас, гунигт автсан бол тэврэх, нурууг нь илэх зэрэг үйлдлийг дадал болгоорой. Таны хүүхэдтэйгээ харилцах дотно, нээлттэй харилцаа амьдралын тань үнэлж баршгүй эрдэнэс юм.

2019 оны 9-р сар



ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.09.08-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭРГЭН ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛ 1.3 ИХ НАЯД ТӨГРӨГТЭЙ ТЭНЦЭЖ БАЙНА

Үйл явдлын товч:

2011 онд Монгол улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч гэж Хөгжлийн банкыг байгуулсан. Энэ банкны санхүүжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн улсын хөгжилд оруулж байгаа өгөөжийг хэмжих байтал зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа асуудал банкинд үүсчээ. Хөгжлийн банкнаас зээл аваад эргэн төлөөгүйгээс 1.2-1.3 их наяд төгрөгийн асуудал яригдаж байгаа гэж ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ Улсын ерөнхий прокурорт зээлээ төлөхгүй байгаа компаниудыг өглөө.

Дүгнэлт тайлбар:

Хөгжлийн банкин дээр зээл нэртэй залилан болж байна. Зээл авсан компаниуд зээлээ эргэн төлөхгүй байна. Хамгийн эхлээд Хөгжлийн банкны одоогийн санхүүгийн үзүүлэлт ямар байгааг танилцуулна уу?

Энэ банк байгуулагдаад 8 жил болж байгаа. Монгол улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч банк гэсэн гоё зорилгоор эхлүүлсэн. Санхүүгийн үзүүлэлт нь 2019 оны I улирлын байдлаар нийт актив 4 их наяд 244 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 1 их наяд 138 тэрбум төгрөг, пассив 3 их наяд 106 тэрбум төгрөг байна. Тайлант хугацааны байдлаар нийт зээлийн үлдэгдэл 2 их наяд 577 тэрбум төгрөг, эрсдлийн сан 336 тэрбум төгрөг байгаа бол чанаргүй зээлийн хэмжээ 292 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Чанаргүй зээлийн харьцаа 10.4 хувьтай байна.

Одоо зээл авчихаад зээлээ төлөхгүй байгаа компанийн асуудал рүү орёе. Хэний эзэмшдэг ямар компаниуд байна? Төр мөнгөтэй байж болохгүйн хамгийн тод жишээ мөн үү?

"ЗГХЭГ-аас Улсын Ерөнхий прокурорт хандан хоёр бичиг явуулсан. Түүний нэг нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээл аваад эргэн төлөөгүй төрд хохирол учруулж байгаа гэж үзэн

1. Эрэл компани
2. Хөтөл компани
3. ТОСК (Төрийн орон сууцны корпораци)
4. Монгол драй милк компани
5. Кью Эс Си компани
6. Капитал банкыг прокурорын байгууллагад өгсөн. Хөгжлийн банкнаас зээл аваад эргэн төлөөгүйгээс 1.2-1.3 их наяд төгрөгийн асуудал яригдаж байна" гэж ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ хэлсэн.

ТОСК-ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ

Авсан зээл: 355.5 тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл: 257.5 тэрбум төгрөг

Төлж барагдуулах хугацаа: 2024.12.01

Хэрэгжүүлсэн төсөл:

- Буянт-Ухаа 1 орон сууцны хороолол
- Буянт-Ухаа 2 орон сууцны хороолол
- Барилга хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор
- Шинэ яармаг орон сууцны хороолол

КЬЮ ЭС СИ компани

Авсан зээл: 187.6 тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл: 161.3 тэрбум төгрөг

Төлж барагдуулах хугацаа: 2018.12.03

Хэрэгжүүлсэн төсөл: Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дахь Төмөртэйн уурхайгаас Ерөө суманд орших "Болд төмөр Ерөө гол" компанийн төмөр замын Хандгайт өртөө хүртэл барих 33.4 км төмөр замын төсөл

ХӨТӨЛ компани

Авсан зээл: 161.5 тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл: 161.5 тэрбум төгрөг

Төлж барагдуулах хугацаа: 2020.10.19

Хэрэгжүүлсэн төсөл: Хөтөл "Цемент шохой" компанийн технологийн шинэчлэл

ЭРЭЛ КОМПАНИ

Авсан зээл: 99.5 тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл: 99.5 тэрбум төгрөг

Төлж барагдуулах хугацаа: 2026.12.20

Хэрэгжүүлсэн төсөл: Байшин үйлдвэрлэх комбинат үйлдвэрийн төсөл

МОНГОЛ ДРАЙ МИЛК компани

Авсан зээл: 39.4 тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл: 39.4 тэрбум төгрөг

Төлж барагдуулах хугацаа: 2023.12.19

Хэрэгжүүлсэн төсөл:

- Хуурай сүү төсөл
- Сумдад хуурай сүүний 60 цех байгуулах



Төрийн шийдвэр тогтвортой биш, төрд гарсан нам өмнөх намынхаа шийдвэрийг үгүйсгэдэг, бусад намтай холбоотой бизнесийг ялгаварлан гадуурхдаг, өөрийн хамаарал бүхий бизнестэй хэт сүлбэлдэж ашигтай биш гэж мэдсээр байж зээл өгдөг зэргээр Хөгжлийн банкны зээлүүд бүгд л улс төржиж явсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Хөгжлийн банкны шинээр томилогдсон захирал Г.Амартүвшин “Арилжааны банкуудын бие даан санхүүжүүлэх боломжгүй, далайцтай, эдийн засагт том хэмжээний өөрчлөлтийг бий болгох, олон тооны ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 20 тэрбум төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш хэмжээтэй санхүүжилтийг Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлнэ. 20 тэрбум төгрөгөөс доош мөнгөн дүнтэй төсөл хөтөлбөрийг Арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлнэ” гэж хэлж байна.

Хэн зээлтэй компаниудаас мөнгөө буцааж авах асуудлыг хөөцөлдөх үүрэгтэй юм бэ? Хөгжлийн банк өөрийн хуультай байгууллага шүү дээ.

Хөгжлийн банкны хуулинд санхүүжүүлсэн төслүүд нь зээлээ төлөхгүй бол яах талаар юу ч байхгүй буюу Хөгжлийн банкны санхүү, төлбөрийн чадварын хэвийн, тогтвортой байдлыг хангах цогц арга хэмжээг Засгийн газар авна гэсэн байгаа юм.

Энэ нь үндсэндээ Хөгжлийн банк болохгүй бол төсвөөс санхүүжүүлээд алдагдлыг нь арилгаад явах санаатай заалтууд юм.

Энэ банк нэртэй улс төрчдийн кассыг яаж ашигтай ажилладаг банк болгох вэ, бүр цаашилбал энэ байгууллага орших бодит шаардлага байна уу?

Банкны зээлийг авсан этгээд нь биш гуравдагч тал төлдөг явдал зөвхөн Монголд л байна. Зээлийг захиран зарцуулсан этгээд биш, харин ажлаа хийлгэсэн “эзэн” нь төлж буй бол үүнийг олгосон газрыг банк биш, бэлэн мөнгөний касс гэдэг. Кассаа банк гэж томоор нэрлэснээр нэг талаас гадаадаас хөрөнгө босгоход, нөгөө талаас төсвөөс гадуур санхүүжилт хийх сайхан боломж гэдгийг 2011 онд төр засгийн эрхийг эвсэн барьж ирсэн хүмүүс-МАНАН, тэдний цаад эзэд нь нарийн тооцоолсон. Хөгжлийн банкны хууль ёсны, де-юре эзэн нь монголын Засгийн газар учраас зээлийн эргэн төлөлтөө хийхгүй байгаа компаниуд болон чанаргүй болсон зээлийг улсын төсвөөс буюу иргэд бидний татвараар төлөх гэж байна.

Хөгжлийн банкнаас зээл авсан компаниудын заримынх нь бизнес үнэхээр явахгүй байгаа бол нөгөө хэсэг нь зээлээ санаатайгаар төлөхгүй байгаа. Яагаад гэвэл төлбөрийг нь төсвөөс хийнэ гээд баталгаажуулчихсан шүү дээ.

Шоглоомтой нь 2018 оны ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр Хөгжлийн банк шалгарч байв. Уг шалгаруулалтыг борлуулалтын орлого, татварын орлого, ажиллагсдын тоо, ашгийн хэмжээ, хөрөнгийн хэмжээ гэсэн 5 үзүүлэлтээр хамтарсан ажлын хэсэг байгуулан албан ёсны мэдээ тайланд үндэслэн жагсаадаг гэж байгаа. Хөгжлийн банк 2017 онд ТОП-100 аж ахуйн нэгжийн 35-д жагссан бол 2018 онд 28-д орсон юм даа. Ийм дампуу банк яахаараа ч энэ шалгаруулалтад ороод явдаг юм! Өндөр татвар төлсөн гэж байгаа бол хэний мөнгөөр тэр татвараа төлснийг нь анхаарах хэрэгтэй байгаа юм.

Энэ банк орших шалтгаан байгаа юу гэдгийг бодох л асуудал.

Хэвлэх

23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

23.1.Засгийн газар Хөгжлийн банкны талаар Компанийн тухай хуулийн 62.1-д заасан хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Хөгжлийн банкны буцаан худалдан авах нөхцөлтэй гаргасан урт хугацаат үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх;

23.1.2.Хөгжлийн банкны санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлтийг баталж, түүний үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийн хамт Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх;

23.1.3.Хөгжлийн банкны санхүү, төлбөрийн чадварын хэвийн, тогтвортой байдлыг хангах цогц арга хэмжээ авах;

23.1.4.Хөгжлийн банкны дүрмийг батлах;

23.1.5.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

23.1.6.Хөгжлийн банкны үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хоёр жил тутамд ээлжит хяналт, шалгалт хийх ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хяналт, шалгалт хийх;

23.1.7.Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг батлах;

23.1.8.Засгийн газраас Хөгжлийн банкинд баталгаа гаргаж болох ба уг харилцааг Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

23.2.Засгийн газар Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй.

Хэвлэх

СТАНДАРТ БАНКИНД ТӨЛСӨН 40 САЯ ДОЛЛАРЫГ ХЭН БУЦААЖ ТӨЛӨХ ВЭ?**Үйл явдлын товч:**

ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ Улсын Ерөнхий прокурорт 2 албан бичиг өгсний нөгөөх нь Жаст группын Стандарт банкнаас зээлсэн мөнгийг Эрдэнэт үйлдвэрийн Эрсдлийн сангаас төлсөн асуудал байв. Стандарт банкинд 40 сая доллар төлсөн гэдгийг Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал Бадамсүрэн болон шадар сайд Энхтүвшин нар энэ оны 4-р сард албан ёсоор мэдэгдэж байсан.

Дүгнэлт тайлбар:

2019 оны 4-р сард Стандарт банкинд 40 сая доллар төлсөн тухай мэдээллийг хэрхэн зарлаж байсныг эргэн санавал.

Шадар сайд Ө.Энхтүвшин:

Жаст группын захирал Х.Батхүү 2009-2010 онд Стандарт банктэй зээлийн гэрээ байгуулж, 2012 он хүртэл удаа дараа нэмж зээл авснаар 160.1 сая ам.долларыг авсан. Үүнийг хугацаандаа төлөөгүй тул Лондонгийн арбитраж хандсан байдаг. Стандарт банк 86.95 сая ам.долларыг Эрдэнэт үйлдвэрээс нэхэмжилсэн. Манайх энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд 2016 оны 9-р сарын 20-ны хуралдааны шийдвэрээр Эрдэнэт үйлдвэрээс нэхэмжилсэн хэмжээгээ багасган 51 сая ам.доллар болгосон. Бид мөн эсэргүүцэн, дээд шүүхэд давж заалдах гомдлоо өгсөн. Ингэхэд эхлээд нэхэмжилж буй 51 сая ам.долларыг төлсний дараа дээд шүүхэд хандаж, шийдвэрлүүлэх боломжтой гэсэн. Харин тухайн үед бидэнд тэр хэмжээний мөнгийг төлөх боломж байгаагүй. Мөн үүнтэй зэрэгцэн Стандарт банкнаас Английн дээд шүүхэд энэ мөнгийг яаралтай төлүүлэхээр шийдвэрлэж өгөөч гэж хандсан байсан. Гэтэл Английн дээд шүүх 2018 оны 7-р сарын 6-нд хуралдаж, Эрдэнэт үйлдвэрийн Англи болон Уэльсийн нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийг гаргахгүй байх, Арбитраж шүүхээр тогтоосон 41.22 сая ам.доллар, хэрэг шийдвэрлүүлэхтэй холбоотой гарсан зардал 476.8 мянган фунт стерлингтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнг даруй компанийн дансанд байршуулах, эсвэл нэгдүгээр зэргийн банкинд баталгаа гаргах шийдвэрийг гаргасан. Нэгэнт энэ

бол эцсийн шийдвэр тул үүнийг биелүүлэхгүй байх ямар ч эрхгүй болсон. Ингээд Ерөнхий сайдын захирамжаар 2018 оны 8-р сард Ажлын хэсэг байгуулсан. Стандарт банкны өрийг барагдуулахгүй бол гуравдагч этгээдэд зарах эрсдэл, гадна талд байгаа хөрөнгүүдийг хураах эрсдэл ч байсан тул төлөх нь зүйтэй юм гэсэн шийдвэр гаргасан. Тиймээс эхний ээлжинд гадна талд байгаа өр төлбөрөө төлөөд, дараа нь дотооддоо асуудлаа шийдэх буюу буруутай этгээдүүдэд хариуцлага тооцье гэсэн. Өнөөдрийн байдлаар 40 сая ам.долларыг ямар нэг хүү байхгүйгээр нэн яаралтай төлөх тохиролцоонд хүрч, энэ мөнгийг Эрдэнэт үйлдвэрийн Эрсдлийн сангаас гаргаж Стандарт банк руу шилжүүлсэн. Хуулийн байгууллага, дээд шүүхийнхэн энэ асуудал дээр хөдлөхгүй байсан. Одоо шуурхай ажиллах байх. Өр төлснөөс болж Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаа ямар нэг хэмжээгээр доголдохгүй.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн:

Эрдэнэт үйлдвэр шиг өргөн цар хүрээтэй ажилладаг байгууллагад Эрсдлийн сан байх ёстой учраас бид ном журмынх нь дагуу байгуулсан. Эрдэнэт үйлдвэр болон Монгол улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн асуудлыг шийдвэрлэхэд энэ сан тус боллоо. Үүнээс болж Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаа ямар нэг хэмжээгээр доголдохгүй.

Дээрх 2 албан тушаалтан ингэж мэдэгдэж байлаа. Эрдэнэт бол төрийн өмчит үйлдвэрийн газар. Гэтэл хувийн компанид баталгаа гаргаад өгчихсөн, тэр компани нь зээлээ төлж чадахгүй болмогц би баталгаа гаргасан юм аа гээд Эрдэнэт үйлдвэр төлж л байдаг. Бас болоогүй энэ мөнгийг төлчихөд Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаа доголдож, данс хотойхгүй гэж ярьж суудаг даргатай үйлдвэр л дээ.

Асуудал үйл ажиллагаа доголдож, данс хотойхдоо биш, энэ төлсөн 40 сая долларыг эргээд хэнээс авах вэ? гэдэгт байгаа юм. Одоо байгаа засаг үүнийг шийдэхгүй боллоотой. Учир нь энэ олон жилийн ууж идсэн, хулгайлж дээрэмдсэн асуудал нэмэгдсээр, хөлөг онгоцоор бол ёроолд нь далайн элдэв зүйлс наалдсаар сум нэвтрэхгүй хэмжээнд зузаарсантай адил болж дээ.

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com

ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛЫН ҮЕЭР МОНГОЛЫН ТАЛЫН САНААЧЛАГА МУУ БАЙСАН УУ?

Үйл явдлын товч:

Өнгөрч байгаа Мягмар гарагт ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин манай улсад айлчилсан. Энэ нь түүний 4 дэх удаагийн айлчлал байсан юм.

Дүгнэлт тайлбар:

Айлчлалын үеэр иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээнд гарын үсэг зурсан. Манай улс 192 улстай дипломат харилцаа тогтоосноос Хятад, Орос, Энэтхэг, Япон, Америк гэсэн 5 улстай стратегийн түншлэлийн харилцаатай. Энэ 5 улсаас иж бүрэн стратегийн түншлэл 2 хөрштэй хийгдсэн. П.Очирбат гуайн үед 20 жилээр энэ гэрээг зурсан байсан ба энэ удаа 20 жилийн хугацааны түншлэл дуусаад хугацаагүй болгож байна.

Айлчлалын хүрээнд хоёр орны Засгийн газар хооронд 10 баримт бичигт гарын үсэг зурж, хамтран ажиллахаар болсон гэж байгаа. Үүнд:

1. Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин нар
2. Терроризмтой тэмцэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Гадаад хэргийн сайд Сергей Викторович Лавров нар
3. Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн сайд Максим Станиславович Орешкин нар
4. Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн үйлчлэлийг сунгах тухай Засгийн газар хоорондын протоколд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батбилэг, Цэрэг-техникийн хамтын ажиллагааны холбооны албаны нэгдүгээр орлогч захирал Андрей Артурович Бойцов нар
5. Монгол-Оросын Улсын хил дээр Хиагт-Алтанбулаг олон улсын авто-замын хилийн боомтын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон ОХУ-ын Холбооны Гаалийн алба хоорондын протоколд Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Холбооны гаалийн албаны дарга Владимир Иванович Булавин нар
6. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба хоорондын стратегийн хамтын ажиллагааны 2020-2024 оны төлөвлөгөөнд Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Холбооны гаалийн албаны дарга Владимир Иванович Булавин
7. Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Оросын Холбооны Улсын “Росгеологи” хувьцаат нийгэмлэг /төрийн өмчит компани/ хоорондын хэлэлцээр“-т Ашигт малтмал газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Улсын “Росгеологи” хувьцаат нийгэмлэгийн ерөнхий захирал Сергей Николаевич Горьков нар
8. “Монгол Шуудан” ХК болон Оросын Холбооны Улсын “Орос шуудан” холбооны төрийн нэгдсэн үйлдвэр хоорондын Стратегийн хамтын ажиллагааны хэлэлцээрт “Монгол Шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатар, ОХУ-ын “Орос шуудан” холбооны төрийн нэгдсэн үйлдвэрийн ерөнхий захирал Николай Радиевич Подгузов нар
9. Эрдэнэс Монгол ХХК болон Оросын Холбооны Улсын “Россети” олон нийтэд нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт “Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү, “Россети” олон нийтэд нээлттэй хувьцаат нийгэмлэгийн ерөнхий захирал Павел Анатольевич Ливинский нар
10. Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК болон Оросын Холбооны Улсын Шууд хөрөнгө оруулалтын сан хоорондын харилцан ойлголцлын хэлэлцээрт “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ний захирал Д.Болормаа, ОХУ-ын Шууд хөрөнгө оруулалтын сангийн ерөнхий захирал Кирилл Александрович Дмитриев нар тус, тус гарын үсэг зурсан.

Гэхдээ бидний хамгийн өндөр хүлээлттэй байсан төмөр зам, шатахуун, эрчим хүчний асуудлууд байрнаасаа огт хөдөлсөнгүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Casa Da Vinci

ХАУСНЫ ХОТХОН



ХУВИЙН
ЭДЭЛБЭР ГАЗАР



ИТАЛИ
ХЭВ МАЯГ



CLUB HOUSE,
CONCIERGE ҮЙЛЧИЛГЭЭ



НОГООН
БАЙГУУЛАМЖ



ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭ



"CONTROL 4" ГЭРИЙН
УХААЛАГ СИСТЕМ



НОГООН БАЙГУУЛАМЖ



ХУВИЙН ОРОН ЗАЙ



ИТАЛИ ХЭВ МАЯГ